



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.17 № 150

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ий 2012 он, 2013 оны эхний 9 сарын санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдлийн аудит хийлээ.

Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн салбарын "Русь" дэлгүүр, харъяа 3 агуулах, Эмнэлэг сувилалын алба дахь эргэлтийн эмийн сан зэрэг газруудад бараа материалын худалдан авалт, зарцуулалтад тавих хяналт алдагдсан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтыг хөтлөөгүй, удирдах албан тушаалтнуудын хүлээн авалтын зардлын лимитийг хэтрүүлсэн зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Санхүү эдийн засгийн сайд, Үндэсний Статистикийн газрын даргын 2002 оны 171/111 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн дээрх алдаа зөрчлийг зогсоож, цаашид давтан гаргахгүй ажиллахыг Эрдэнэт үйлдвэрийн Ерөнхий захирлын Нийгмийн асуудал хариуцсан орлогч С.Сувдаа, Ерөнхий нягтлан бодогч Платонов М.В-д нарт үүрэг болгож албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТОР**

Танилцаж зөвшөөрсөн:  
Ерөнхий захирлын Нийгмийн асуудал  
хариуцсан орлогч

Ерөнхий нягтлан бодогч

**П.ЧАНЦАЛДУЛАМ**

С.Сувдаа

Платонов М.В



070393